



МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН  
ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2021 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот


Журам батлах тухай


Өмгөөллийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4.11 дэх хэсэг, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны дүрмийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, мөн дүрмийн 23 дугаар зүйлийн 23.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын Өмгөөлөгчдийн холбооны “Ахмадын хорооны ажиллах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тогтоолыг 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

  
Б.БААТАРСАЙХАН



## МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ АХМАДЫН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

### 1 дүгээр зүйл. Журмын зорилго

1.1. Энэхүү журмаар Монголын Өмгөөлөгчдийн Холбооны дэргэдэх Ахмадын хороо /цаашид "Ахмадын хороо" гэнэ/-ны зохион байгуулалт, үйл ажиллагаа, ахмадуудын эрх ашгийг хамгаалах, тусламж, дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

### 2 дугаар зүйл. Ахмадын хорооны зохион байгуулалт

2.1. Ахмадын хороо нь энэ журмын 3.2.1, 3.2.2-т заагдсан бэлээл, шаардлагыг хангасан ахмадуудыг эгнээндээ нэгтгэсэн, ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог бэхжүүлэх, ахмадуудын эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах зорилготой Монголын Өмгөөлөгчдийн Холбоо /цаашид "Холбоо" гэнэ/-ны дэргэдэх байгууллага байна.

2.2. Холбооны Ерөнхийлөгч Ахмадын хорооны даргыг томилно.

2.3. Холбооноос Ахмадын хорооны үйл ажиллагаа явуулахад санхүүгийн болон бусад тусламж, дэмжлэг, хөнгөлөлтийг үзүүлж болно.

### 3 дугаар зүйл. Ахмадын хорооны гишүүн, түүний бүртгэл

3.1. Ахмадын хороонд бүртгэж, үнэмлэх олгосноор "Ахмадын хорооны гишүүн" болно.

3.2. Ахмадын хорооны гишүүнээр дор дурдсан хүнийг бүртгэнэ:

3.2.1. Өмгөөлөгчөөр 20-иос доошгүй жил ажилласан, бусад Ахмадын байгууллагад бүртгэлгүй 55 нас хүрсэн эмэгтэй, 60 нас хүрсэн эрэгтэй;

3.2.2. Холбоонд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтан.

3.3. Энэхүү журмын 3.2-т заасан хүн Ахмадын хороонд бүртгүүлэх хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд дор дурдсан баримтыг хавсаргасан байна:

3.3.1. анкет;

3.3.2. иргэний үнэмлэхийн хуулбар;

3.3.3. тэтгэврийн дэвтрийн хуулбар;

3.3.4 өмгөөлөгчөөр 20-иос доошгүй жил ажилласныг нотлох баримт.

### 4 дүгээр зүйл. Ахмадын хорооны үйл ажиллагаа

4.1. Ахмадын хороо дор дурдсан үйл ажиллагаа явуулна:

4.1.1. Холбоо, салбар зөвлөлөөс явуулж буй үйл ажиллагаанд оролцох;

4.1.2. Ахмадын хорооны гишүүдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд зориулан хүндэтгэлийн болон нийгэм, соёлын арга хэмжээг зохион байгуулах;

4.1.3. Ахмадын хорооны гишүүн, өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлдэг өмгөөлөгчдийг Холбооны гишүүнчлэлийн хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх талаар санал гаргах;

4.1.4. Ахмадын хорооны гишүүнийг төрийн болон Холбооны шагналаар шагнуулахаар санал гаргах;

4.1.5. Ахмадын хорооны гишүүний санал, хүсэлтийг хүлээн авч, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

4.1.6. залуу үеийг халамжлан хүмүүжүүлэх;

4.1.7. өмгөөлөгчийн мэргэжил, өмгөөллийн үйл ажиллагааг сурталчлан таниулах;

4.1.8. бусад.

#### **5 дугаар зүйл. Ахмадын хорооны санхүүжилт**

5.1. Ахмадын хорооны санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

5.1.1. Холбооноос олгосон мөнгөн хөрөнгө;

5.1.2. хандив, тусламж;

5.1.3. хуульд заасан бусад.

5.2. Энэхүү журмын 5.1.2-т заасан санхүүжилтийг хүлээн авах, захиран зарцуулахад Монголын Өмгөөлөгчдийн Холбооны дүрмийн 66.3-т заасан журмыг баримтална.

5.3. Холбооны Ерөнхийлөгч Ахмад хорооны даргын хүсэлтийг үндэслэн санхүүжилтийг тухай бүр олгоно.

5.4. Ахмадын хорооны санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг Хяналтын зөвлөл хэрэгжүүлнэ.

#### **6 дугаар зүйл. Журам хүчин төгөлдөр болох**

6.1. Энэ журмыг 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

--- о О о ---

